

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ аваахаар нийт 63 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Тус эмнэлгээс ирүүлсэн мэдээллээр Нүдний даралтын кабинетэд үзүүлэхээр 49 үйлчлүүлэгч 7-с дээш хоног хүлээж байгаа нь амбулаторийн хамгийн их хүлээгдэлтэй тусламж үйлчилгээнд хамаарч байна.

Оношилгооны чиглэлээр тусламж, үйлчилгээний хүлээгдэлгүй бүртгэгдээгүй байна. Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1741 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь өмнөх сараас 200 гаруй үйлчлүүлэгчжр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Нүдний тасаг	3-6 хоног	63
		7-14 хоног	85
		15-30 хоног	198
		1 сараас дээш	470
	Нийт		816
2	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	15
		7-14 хоног	29
		15-30 хоног	51
		1 сараас дээш	403
	Нийт		498
3	БШГМЗ тасаг	3-6 хоног	5
		7-14 хоног	17
		15-30 хоног	38
		1 сараас дээш	104
	Нийт		164
4	Урологийн тасаг	3-6 хоног	24
		7-14 хоног	30
		15-30 хоног	55
		1 сараас дээш	20
	Нийт		129
5	Мэс заслын тасаг	3-6 хоног	23
		7-14хоног	25
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
	Нийт		48
6	Зүрх судас судлал		3
		7-14хоног	7
		15-30 хоног	-

		1 сараас дээш	20
	Нийт		30
7	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	6
		7-14 хоног	10
		15-30 хоног	9
		1 сараас дээш	1
	Нийт		26
8	Цусны эмгэг судлал	3-6 хоног	7
		7-14хоног	4
		15-30 хоног	1
		1 сараас дээш	-
	Нийт		12
9	Бөөр судлал	3-6 хоног	2
		7-14хоног	4
		15-30 хоног	2
		1 сараас дээш	-
	Нийт		8
10	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	3
		7-14хоног	1
		15-30 хоног	1
		1 сараас дээш	-
	Нийт		5
11	Уушиг судлал	3-6 хоног	3
		7-14хоног	-
		15-30 хоног	1
	Нийт		4
12	Хэрх үе судлал	3-6 хоног	1
	Нийт		1
	БҮГД	3-6 хоног	155
		7-14хоног	212
		15-30 хоног	356
		1 сараас дээш	1018
	НИЙТ		

Нүдний тасагт хэвтэхээр нийт 816 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь эмнэлгийн хэмжээнд нийт орны хүлээгдлийн бараг тал хувийг / 47%/ эзэлж байгаа ба 470 үйлчлүүлэгч 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Нүдний хиймэл болорын нөөц дуссантай холбоотой болор солиулахаар хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо ийнхүү ихээр нэмэгдсэн байна.

Мөн Чих хамар хоолойн тасагт хэвтэж эмчлүүлэхээр 498 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн дийлэнх буюу 81% /403/ нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сартай ижил түвшинд байна. Нийт 142 үйлчлүүлэгч амбулаторийн 7 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн

тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	1	1	35	37
2	Мэс засал судлал	2	2	21	25
3	Мэдрэл судлал	1	-	23	24
4	Нүд судлал	-	-	22	22
5	Эмэгтэйчүүд судлал	9	7	2	18
6	Бөөр судлал	1	1	12	14
7	Зүрхний эмгэг судлал	2	-	-	2
	НИЙТ	16	11	115	142

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр 142 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 81% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 61 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь мөн л өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна. Хэвлийн эхо-д харуулахаар 36, Рентген оношилгоо хийлгэхээр 13, MRI оношилгоо хийлгэхээр 10 үйлчлүүлэгч тус тус хүлээж байгаа ба дийлэнх буюу 69% нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Шинжилгээ өгөхөөр нийт 53 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 43 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл маш ихтэй байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 384 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Чих хамар хоолойн тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 161 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Чих, хамар, хоолой судлал	16	20	40	85	161
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	24	43	-	-	67
3	Зүрх судасны эмгэг судлал	18	31	15	-	64
4	Мэс засал судлал	45	-	-	-	45
5	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	15	10	-	-	25
6	Мэдрэл судлал	8	-	-	-	8
7	Уушиг судлал	5	3	-	-	8
8	Урологи	-	3	-	-	3
9	Бөөрний эмгэг судлал	-	3	-	-	3
	НИЙТ	131	113	55	85	384

Мөн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 67, Зүрх судасны эмгэгийн тасагт эмчлүүлэхээр 64 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байна. Хэвтүүлэн эмчлүүлэхээр ор хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн талаас илүү буюу 63% /244/ нь 2 долоо хоног хүртэл хугацаагаар ор хүлээж байна.

3. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 493 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь 2023 оны 3 сараас 20 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 96% /476/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 4/.

Хүснэгт 4 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	1	108	109
2	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	-	57	57
3	Зүрх судас судлал	6	48	54
4	Хими	3	49	52
5	Туяа эмчилгээ	2	45	47
6	Толгой, хүзүүний мэс засал	-	45	45
7	Ерөнхий мэс засал	-	43	43
8	Хөхний төв	-	40	40
9	Ангиографи	1	23	24
10	Элэг судлал	2	12	14
11	Цээжний хөндийн мэс засал	1	4	5
12	Сэргээн засах	1	1	2
13	Ерөнхий хавдар судлал	-	1	1
	Нийт	17	476	493

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 109, Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын эмчид үзүүлэхээр 57, Зүрх судасны эмчийн зүлэгт орохоор 54 Хими эмчилгээний үзлэгт орохоор 52 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлгийн оношилгооны тусламж үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 181 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 70 гаруй үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 68, Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 50, хэвлийн эход харуулахаар 23, ходоод дурандуулахаар 21 хүн тус бүр 7-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ их хүлээгдэлтэй, нийт 458 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 65 үйлчлүүлэгчээр цөөрсөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 5/.

Хүснэгт 5 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Өдрийн хими	15	75	120	7	217
2	Хими	2	14	77	1	94
3	Ангиографи	3	10	22	-	35
4	Хөнгөвчлөх	4	6	17	1	28
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	1	11	12	2	26
6	Ерөнхий мэс засал	-	5	10	-	15
7	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	3	11	-	14
8	Туяа	1	3	6	-	10
9	Дуран	-	2	8	-	10
10	Толгой, хүзүүний мэс засал	1	2	1	-	4
11	Хөхний төв	-	1	3	-	4
12	Цээжний хөндийн мэс засал	-	1	-	-	1
	Нийт	27	133	287	11	458

Тус эмнэлэгт өдрийн болон хими эмчилгээ хийлгэхээр нийт 311 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн өндөр хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламжид хамаарч байгаа ба энэ нь нийт хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 68%-ийг эзэлж байна. Ангиографиийн тасагт хэвэхээр 35 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчигээнд орж байна.

4. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ өмнөх саруудтай харьцуулахад хүлээгдэл ихтэй байна. Нийт 556 үйлчлүүлэгч амбулаторид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байна./Хүснэгт 6/

Хүснэгт 6. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэдрэл судлал	1	2	91	94
2	Зүрх судас судлал		2	79	81
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	2	61	65
4	Бөөр судлал	1	7	47	55
5	Булчирхай судлал	1	6	45	52
6	Зүрхний мэс засал	2	33	5	40
7	Уушиг судлал	1	1	29	31
8	Нүд	-	-	28	28

9	Чих хамар хоолой	-	2-	24	24
10	Урологи	3	-	21	24
11	Мэдрэлийн мэс засал	-	-	24	24
12	Мэс засал	8	10	2	20
13	Сэргээн засах	2	3	3	8
14	Уламжлалт эмчилгээ	3	2	2	7
15	Сонсгол судлал	-	1	2	3
	НИЙТ	24	69	463	556

Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 94, зүрхний эмчид үзүүлэхээр 81, Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын эмчийн үзлэгт орохоор 65, Боорний эмчид үзүүлэхээр 55 үйлчлүүлэгч 2-с дээш хоног тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Амбулаторийн хүлээгдлийн дийлэнх буюу 83% нь 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 55, зүрхний эхо-д харуулахаар 23 үйлчлүүлэгч, дурангийн оношилгоо хийлгэхээр 15, Тархины цахилгаан бичлэг, доплер хийлгэрээх тус бүр 14, хэвлийн эход харуулахаар 13 үйлчлүүлэгч, рентгенд харуулахаар 11, Холтер багажийн оношилгоо хийлгэхээр 7, нийт 152 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй байна.

2023 оны 4 сард тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ нь мөн адил хүлээгдэл ихтэй, 132 үйлчлүүлэгч шинжилгээ өгөхөөр 2-с дээш хоног хүлээж байна. /Хүснэгт 7/.

Хүснэгт 7. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Цусны шинжилгээ	20	17
2	Бактерлогийн шинжилгээ	21	5
3	Биохимийн шинжилгээ	27	-
4	Шээсний шинжилгээ	20	12
5	Иммунологи	9	
	НИЙТ	97	35

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 225 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сараас 20 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 85 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тасагт хамаарч байна. / Хүснэгт 8/

Хүснэгт 8. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 3 тасгийн мэдээ

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	-
		7-14хоног	10
		15-30 хоног	25
		1 сараас дээш	50
		Нийт	85

2	Мэс заслын тасаг	3-6 хоног	33
		7-14хоног	15
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	48
3	Уушиг судлалын тасаг	3-6 хоног	17
		7-14хоног	1
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	18

Мэс заслын тасагт хэвтэхээр 48, уушигны тасагт хэвтэн эмчлүүлэхээр 18 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоногоор ор хүлээж байна.

5. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 20 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ойролцоо түвшин, харьцангуй хүлээгдэл багатай байна./ Хүснэгт 9/

Хүснэгт 9. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	3 хоног	13
2	4-6 хоног	3
3	7-с дээш хоног	4
	Нийт	20

Тус эмнэлэгт MRI оношилгооны хүлээгдэл маш их, нийт 490 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас даруй 100 гаруй үйлчлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй, хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарч байна. Мөн хэвлийн эхо-д харуулахаар 3 үйлчлүүлэгч тус бүр 3-6 хоногийн хүлээгдэлтэй байлаа. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байна.

6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 58 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 104 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь 3 сарын үзүүлэлттэй харьцуулахад 32 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. 21 үйлчлүүлэгч 3-6 хоног, 11 үйлчлүүлэгч 7-14 хоног, 71 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус ор хүлээж байна. Оношилгоо болон лабораторийн тусламж үйлчилгээ хүлээгдэлгүй байна.

7. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх сарын адилаар хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 152 үйлчлүүлэгч 3-6 хоног, 94 үйлчлүүлэгч 7-14 хоног, 59 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 305 хүн хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хамгийн их

хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. MRSA халдвар эмчлүүлэхээр нийт 15 үйлчлүүлэгч ор хүлээж байна.

8. Геронтологийн үндэсний төв нь 2023 оны 4 дүгээр сард хүлээгдэлгүй ажиллаж байна.
9. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүрээ амаржих газар, Өргөө, Амгалан амаржих газар ТМЭ, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Монгол Улс,
Улаанбаатар хот-210648, Ш/Х-187, Сүхбаатар Дүүрэг, 1-р
хороо, Энхтайвны гудамж-13Б

Утас: 70128801 Факс: 70128801
Цахим шуудан: admin@hdc.gov.mn
Цахим хуудас: hdc.gov.mn

2023.05.01

№

321

танай

-ны №

-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв эмнэлгүүдээс 2023 оны 4 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 8 хуудас.

Хүндэтгэсэн,

